



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2022.09.27 № 5/4353

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


Г НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН  
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН  
ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ ЭМНЭЛГИЙН  
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны  
өдрийн 09 дугаар албан даалгаврыг хүргүүлж байна.

Хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт, хуудастай.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ГАЗРЫН ДАРГА *Ж.НАРАНГЭРЭЛ*



145220870

2022. оны 09 сарын 23 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Өвөлжилтийн үеийн эрүүл мэндийн  
тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг  
хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын 227 дугаар тогтоолын 2.3. дахь заалтыг үндэслэн өөрийн орон нутгийн өвөлжилтийн байдалд үнэлгээ хийж үнэлгээний дүнд үндэслэн эмнэлгийн тусlamж үйлчилгээний бэлэн байдлыг ханган дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, тусгай эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт ДААЛГАСУГАЙ.

**1. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд шаардлагатай нөөцийн бэлэн байдлыг хангах**

- 1.1. Томуу, томуу төст өвчин, коронавируст халдварт (КОВИД-19)-ын дэгдэлтийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгон гүйцэтгэлд онцгойлон анхаарч бэлэн байдлыг хангах;
- 1.2. SARS-CoV-2-ийн шинэ хувилбарын вирусээр үүсгэгдсэн дэгдэлт гарсан үед ажиллах хүний нөөц, байр, эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдвартгүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдлыг хангах;
- 1.3. Зайлшгүй шаардлагатай үед дайчлах санхүүгийн нөөцийг урьдчилан тооцоолсон байх;
- 1.4. Эмнэлгийн байгууллагын халаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэж, түлшний нөөцийг бүрдүүлэх, дулааны шугам, сүлжээний ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилт, тохируулгыг цаг хугацаанд нь дуусгах;
- 1.5. Цахилгааны нөөц эх үүсвэрийн хэвийн найдвартай байдлыг хангах
- 1.6. Яаралтай тусlamжийн үед ашиглах зөвөрийн тоног төхөөрөмжүүдийг бэлэн байлгах, цахилгааны эх үүсвэрээр хангах
- 1.7. Эрүүл мэндийн байгууллагын барилгын урсгал засварыг яаралтай гүйцэтгэх, шинээр баригдаж байгаа барилгын гэрээний биелэлтэд хяналт тавьж, хугацаанд нь ашиглалтад оруулах
- 1.8. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх автомашины засвар үйлчилгээг хийж, шатахууны нөөцийг хангах

143220038

- 1.9. Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, 6-24 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, аминдэмээр хангах

## **2. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах**

- 2.1. Байгалийн болзошгүй аюулт үзэгдлийн үед өөрийн байгууллагын чиг үүргийн дагуу эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шуурхай, тасралтгүй бэлэн байдлыг хangan зохион байгуулах арга хэмжээг авч ажиллах;
- 2.2. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношуур, хүчинтөрөгч, тоног төхөөрөмж, хоол хүнс, ундны ус, шаардлагатай тохиолдолд яаралтай татан авалт хийх, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношуурын чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх, хадгалах, тараах нөхцөлийг бүрдүүлж бэлэн байдлыг хангах
- 2.3. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, ялангуяа алсын дуудлагад томилолтоор ажиллах эмнэлгийн мэргэжилтэн, жолооч бүрийг амь тэнссэн үеийн тусlamж үйлчилгээ үзүүлэх арга барилд сурган дадлагажуулах, дуудлагад гарахын өмнө зориулалтын дулаан хувцас, гутал, үүрэн телефоны утас, цэнэглэгчийн нөөц, хоёр хоногийн хүнс, гар чийдэн, шүдэнз зэрэг нэн шаардлагатай хэрэгслийн бэлэн байдлыг нягтлан, хангуулж явуулж хэвших

## **3. Отор нүүдлээр явж буй малчдад эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх**

- 3.1. Отор нүүдэл хийхээр төлөвлөж буй айл өрх, иргэний бодит тоо, отор нүүдэл хийх зураглалыг гаргаж, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар холбогдох аймаг, сумтай хамтран урьдчилсан төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх
- 3.2. Өвөлжилт хүндэрч болзошгүй баг, сум, аймагт амьдарч байгаа болон отор нүүдэл хийх айл өрхийн 5 хүртэлх насын хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хэвтрийн үйлчлүүлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний судалгааг гаргах, эрүүл мэндийн байдлыг хянаж, зөвлөмж өгөх, эмнэлгийн тусlamж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлэх
- 3.3. Отроор өвөлжих, хаваржих малчдад эрүүл мэндийн тусlamжийг явуулын багаар үзүүлэх хуваарь гаргах, бэлэн байдлыг хангах

## **4. Эрүүл мэндийн ажилтны сургалт, нийгмийн хамгааллыг хангах**

- 4.1. Эмнэлгийн мэргэжилтнийг осголт, хөлдөлт, болзошгүй осол, гэмтлээс сэргийлэх, томуу, томуу тест өвчин, коронавируст халдварт (Ковид-19) - аас урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэлээр давтан сургалтад хамруулан чадавхжуулах, дадлагажуулах
- 4.2. Өрх, сум, тосгоны эмнэлгийн мэргэжилтэн бүрийг чадавхжуулах сургалтад хамруулах, мэдлэгийг дээшлүүлэх
- 4.3. Эрүүл мэндийн ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, тэдний дархлааг дэмжих ажлыг зохион байгуулах

## **5. Мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх**

- 5.1. Иргэдэд хувийн бэлтгэлийг хангах, жирэмсэн эмэгтэй, бага насы хүүхдийг хараа хяналтгүй, орхихгүй байх, хөлдөлт, осголт, коронавируст халдварт (Ковид-19), томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх талаар иргэдийг бодит мэдээллээр тогтмол хангах
- 5.2. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдахын ач холбогдлыг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр сурталчлан таниулах, хамрагдалтыг эрчимжүүлэх
- 5.3. Хүйтэн сэргүүний улиралд ахуйн галлагаатай холбоотойгоор угаарын хийн хордлогод өртөхөөс сэргийлэх, анхны тусlamж үзүүлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр тогтмол түгээх

#### **6. Засаг дарга, орон нутгийн байгууллагуудтай хамтарч ажиллах**

- 6.1. Орон нутгийн Онцгой байдлын газар болон Ус цаг уурын албанаас цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол авч, байгалийн болзошгүй аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, эмнэлгийн тусlamжийг үзүүлэх бэлтгэлийг хангах
- 6.2. Хальтиргаа гулгаа үүсч болзошгүй явган болон авто зам, даваанд замын тэмдэглэгээ хийж, цас мөсийг арилгах, засч сайжруулахыг харьяа аймаг, нийслэл, сумын Засаг дарга, холбогдох байгууллагад санал хургэж тайлан мэдээг авах
- 6.3. Отбор нүүдэл хийж байгаа малчдыг орон нутагт эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэхэд тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамtran ажиллах

#### **7. Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах**


- 7.1. Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн тайланг заалт бүрээр гаргаж 2022 оны 10 дугаар сарын 10-ны дотор тус яамны Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газарт ирүүлэх.

#### **8. Отбор нүүдлээр явж буй иргэдийн судалгааг хавсралтад заасны дагуу тогтсон хугацаанд ирүүлж байх**

- 8.1. Аймаг, нийслэл, сумын өвөлжилтийн байдал, отбор нүүдлээр явж байгаа болон өвөлжилт хүндэрсэн, зудтай бүс нутгийн айл өрх, иргэний бодит тоог 14 хоног тутамд нэгтгэн, сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 17 цагаас өмнө Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газарт албан бичгээр болон цахим хаягаар /bundochir@moh.gov.mn / ирүүлж байх.

Хавсралт... хуудастай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайжрын 2022 оны 09 дугаар  
... сарын 13-өдрийн 09 дугаар албан  
даалгарврын хавсралт


## АЙМАГ СҮМДҮН ОТОР НИУДЛЭЭР ЯВАА ИРГЭДИЙН СУДАЛГАА

### СУДАЛГААНЫ АСУУМЖ НЭГ.

2022 оны ... дугаар сарын ...-ны байдлаар

№	Аймаг, асуумж	Отроор өвөлжилж буй малчдын тоо				Чүнэс:		
		Аймаг дотроо	Өөр сум аймалт	Өөр сум айлагаас ирж	Жириэмсэн эхийн тоо	0-5 насны хүүхдийн тоо	Өндөр настны тоо	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо
1	Нийт	0	0	0				

Бусад: (Шаардлагатай тохиолдолд өвөлжилж хүндэрсэнтэй холбоотой зарим сум, баг, аймгийн нутаг, дэвсгэр, хүн амын эрүүл мэндэд тулгамдсан асуудлаар энд нэмэлтээр бичнэ үү.)



## **СУДАЛГААНЫ АСУУМЖ ХОЁР: ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

№	Аймаг	Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн неөц	Төвлөрсөн халтуун дулаан, хангах системийн байдал	Түлшний хангарт	Түргэн туслаамжийн автомашинны тоо	Шатахууны хүрэлцээ
		388-р Тушаалд заасан эм, эмнэлгийн хэрэгслийн неөц	Хэвийн (+,-)	Нэмэлт неөц шаардлага тай тоо хэмжээ	Хангартай (+,-)	Өрүүссэн Нэмэлт шаардлага тай тоо хэмжээ
		3 сарын неөлгэй (+,-)	Дугагдлтай (+)	Одоо нэмэлт шаардлагатай тоо хэмжээ	Одоо байгаатоо	Дуттуу тоо
1						

Бусад: (Шаардлагатай тохиолдолд өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой зарим сум, баг, аймийн нутаг, дэвсгэр, хүн амын эрүүл мэндэд

Тулгамдсан асуудлаар энд нэмэлтээр бичнэ үү.)